

Аудитын код: САГ-2018/252/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn


Ахлах аудитор Г.Жавхлан
Утас: 261628 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Аудитор Г.Мөнхчимэг
Х.Ундрага
Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
undragakh@audit.gov.mn



Агуулга

Аудитын гэрчилгээ	0
1 Аудитын тайлан.....	3
1.1 Оршил.....	3
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
1.5 Дотоод хяналт	4
1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	5
1.7 Шилэн дансны мэдээлэл	5
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
1.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар.....	5
1.9.2 Үндсэн хөрөнгийн талаар.....	5
1.9.3 Шатахууны зардлын талаар	6
1.9.4 Сэлбэгийн зардлын талаар.....	6
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
2 Менежментийн захидал	8
2.1 Мөнгөн хөрөнгө талаар	
2.2 Үндсэн хөрөнгийн талаар.....	9
2.3 Шатахууны зардлын талаар.....	11
3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/455
танай _____ -ны № _____ -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.ЦЭНГЭЛ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль, орчин аялал жуулчлалын яамны 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0223\SAG30.Docx

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дугаар сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Г.Мөнхчимэг, гэрээт аудитор Х.Ундрага нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/555 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж, ажиллахын тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтууд дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, 2015 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 7 дугаар тушаал зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Ascolous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод хяналт санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор урсгал зардалд 19,523,066.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын гүйцэтгэл нийт 18,459,727.4 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.eec.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон.

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан.

Тайлант онд Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, шийдвэрийн хуулбар хавсаргаагүй байсан мэдээллийг нөхөж оруулсан байна.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар

- Тайлант онд Агаарын бохирдлыг бууруулах, Ойжуулалтын арга хэмжээ, Аялал жуулчлалын хөтөлбөрүүдээс “Байгаль эхийн үзэг тулсан түшээ” ном 350 ширхэгийг 3,600.0 мянган төгрөгөөр, мөн “Өргөн сэлэнгийн давалгаа” ном 400 ширхэгийг 3,500.0 мянган төгрөгөөр нийт 7,100.0 мянган төгрөгийн хөтөлбөрийн зорилгод нийцэхгүй ном худалдаж авсан,
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын хэрэгжүүлж буй “Ойжуулалт ойн арга хэмжээ, Агаарын бохирдлыг бууруулах, Аялал жуулчлал хөтөлбөрт батлагдсан төсвөөс хүүхдийн баярын бэлгэнд зориулж 10,174.8 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийг 16.5.5-г мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөх;

1.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

- Тайлант онд нийт 135,209.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр худалдан авсан,
- Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийгдсэн боловч тооллогын үр дүн, тооцоо бодолт хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т *“эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”*, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолын журмын 1.2 *“Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон Төрийн өмчийн хорооны шийдвэрээр баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, ... ”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

1.9.3 Шатахууны зардлын талаар

Шатахууны талоны тооцоо хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 2,553.2 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

1.9.4 Сэлбэгийн зардлын талаар

Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй Лексус 570 маркийн 0708 УНБ дугаартай авто машинд нийт 1,302.0 мянган төгрөгийн сэлбэг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, батламж мэдэгдлийг хангаж ажиллах. Цаашид зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага өгөх.

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 313,258.7 мянган төгрөгийн авлагын 95.5 хувь буюу 299,514.5 мянган төгрөг нь Цэвэр агаар сантай холбоотой 2015 онд үүссэн авлага байна.

1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын хүрээнд *“Ойн судалгаа хөгжлийн төв”* УТУГ-д шилжүүлсэн зардлын гүйцэтгэлийг үзсэн бөгөөд цаг хугацааны хязгаарлагдмал нөхцлөөс шалтгаалан уг хөтөлбөрийн зарцуулалтыг гүйцэд шалгаж тул дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 156,339.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн

ба 18,576.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 137,762.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 33,300.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,714,405.9 мянган төгрөгийн 2 хувь буюу 174,288.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үед материаллаг байдлын суурь болон хувийг өөрчлөөгүй ба шинж чанар, орчин нөхцөлөөр тооцоход материаллаг шинжтэй зүйл илрээгүй болно.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



2.1 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

- Тайлант онд нийт 135,209.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр худалдан авсан,
- Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийгдсэн боловч тооллогын үр дүн, тооцоо бодолт хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т *“эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”*, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолын журмын 1.2 *“Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон Төрийн өмчийн хорооны шийдвэрээр баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, ... ”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмыг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-нд үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгө сайхүүгийн тайланд бүрэн тусгагдахгүй байх, хөрөнгийн ангилал буруу хийгдсэн байх,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



2.2 ШАТАХУУН, СЭЛБЭГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Шатахууны талоны тооцоо хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 2,553.2 мянган төгрөгийн шатахууны зардал гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ыг мөрдөж цаашид зөрчлийг давтахгүй байх арга хэмжээг авч ажиллаж.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-нд үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, өндөр үнэтэй бараа материал бэлтгэх, Хөрөнгө эзгүйдэх, чанарын шаардлага хангахгүй үхмэл хөрөнгө бий болох, удирдлага буруу шийдвэр гаргах, үргүй зардал гаргах зэрэг эрсдэл бий болж байна.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,115,947,452.94	6,335,182,483.58	
АВЛАГА	336,589,381.33	313,258,750.42	
Ажиллагсадтай холбогдсон авлага	4,800,000.00	00.00	
Татаас санхүүжилтийн авлага	14,368,162.70	00.00	
Бусад авлага	317,421,218.63	313,258,750.42	
Байгууллагаас авах авлага	317,148,280.55	312,484,279.40	
Хувь хүмүүсээс авах авлага	272,938.08	774,471.02	
УРЬДЧИЛГАА	5,584,932,324.00	5,707,238,139.10	
Урьдчилж гарсан зардал	5,584,932,324.00	5,694,960,832.10	
Урьдчилгаа тооцоо	00.00	12,277,307.00	
Томилолтын урьдчилгаа	00.00	12,277,307.00	
БАРАА МАТЕРИАЛ	194,425,747.61	314,685,594.06	
Түүхий эд материал	500,000.00	00.00	
Тусгай зориулалттай материал	500,000.00	00.00	
Хангамжийн материал	193,925,747.61	314,685,594.06	
Бичиг хэргийн материал	10,362,210.00	13,996,094.40	
Аж ахуйн материал	116,454,797.40	288,651,335.25	
Сэлбэг хэрэгсэл	2,322,817.00	1,970,600.00	
Түлш, шатах тослох материал	13,504,950.00	3,302,000.00	
Бусад хангамжийн материал	51,280,973.21	6,765,564.41	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,776,006,071.22	2,511,587,710.83	
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,776,006,071.22	2,511,587,710.83	
Биет хөрөнгө	2,696,972,100.70	2,457,982,361.01	
Барилга, байгууламж, орон сууц	1,349,381,240.00	1,349,381,240.00	
Хуримтлагдсан элэгдэл	(665,467,187.18)	(23,119,744.59)	
Авто-тээврийн хэрэгсэл	368,894,600.00	260,244,600.00	
Хуримтлагдсан элэгдэл	(265,611,162.25)	(201,416,832.22)	
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,727,536,969.02	1,818,094,829.02	
Хуримтлагдсан элэгдэл	(1,257,896,900.92)	(1,462,646,432.96)	
Тавилга, аж ахуйн эд хогшил	824,215,758.12	855,209,563.12	

Хуримтлагдсан элэгдэл	(671,294,466.68)	(725,679,297.68)
Түүх саёл, музейн дурсгалт зүйлс	1,174,000,000.00	1,174,000,000.00
Бусад үндсэн хөрөнгө	129,016,941.00	137,263,441.00
Хуримтлагдсан элэгдэл	(15,806,135.72)	(23,349,004.68)
Биет бус хөрөнгө	79,033,970.52	53,605,349.82
Програм хангамж	22,748,250.00	22,748,250.00
Хуримтлагдсан элэгдэл	(20,747,909.42)	(22,428,250.04)
Бусад биет бус хөрөнгө	242,511,400.00	242,511,400.00
Хуримтлагдсан элэгдэл	(165,477,770.06)	(189,226,050.14)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,891,953,524.16	8,846,770,194.41
НИЙТ ӨР ТӨЛБӨР	198,653,709.00	28,018,756.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	198,653,709.00	28,018,756.00
Өглөг	198,653,709.00	28,018,756.00
Бусад өглөг	198,653,709.00	28,018,756.00
Байгууллагад төлөх өглөг	198,653,709.00	28,018,756.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,693,299,815.16	8,818,751,438.41
Засгийн газрын хувь оролцоо	8,693,299,815.16	8,818,751,438.41
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,954,229,779.25	2,954,229,779.25
Өмч: - төрийн	2,954,229,779.25	2,954,229,779.25
Хуримтлагдсан үр дүн	5,683,631,713.74	5,809,083,336.99
Өмнөх үеийн үр дүн	5,683,631,713.74	5,663,363,161.79
Тайлант үеийн үр дүн	00.00	145,720,175.20
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,438,322.17	55,438,322.17
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,891,953,524.16	8,846,770,194.41



3.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,122,416,104.53	19,444,417,512.45
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,342,998.53	3,253,838.00
Нийтлэг татварын бус орлого	45,342,998.53	3,253,838.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	45,342,998.53	3,253,838.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,342,998.53	3,253,838.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,077,073,106.00	19,441,163,674.45
Улсын төвлөрсөн төсвөөс	7,775,852,091.00	18,459,727,468.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,775,852,091.00	18,459,727,468.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,301,221,015.00	981,436,206.45
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,801,483,296.00	492,149,206.45
ЗГНХ,ЗДНХХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	499,737,719.00	489,287,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,700,037,711.30	19,285,108,417.55
УРСГАЛ ЗАРДАЛ	8,081,070,767.32	9,783,731,962.45
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,081,070,767.32	9,783,731,962.45
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,635,008,394.32	1,676,382,771.11
Үндсэн цалин	1,418,636,146.32	1,385,955,124.76
Нэмэгдэл	00.00	93,599,381.71
Унаа хоолны хөнгөлөлт	125,151,609.00	61,533,448.01
Гэрээт ажлын хөлс	91,220,639.00	135,294,816.63
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,638,538.38	192,934,885.93
Тэтгэврийн даатгал	120,466,200.30	124,509,466.48
Тэтгэмжийн даатгал	8,175,207.48	15,237,962.91
ҮОМШӨ-ний даатгал	16,336,264.97	14,467,458.82
Ажилгүйдлийн даатгал	8,145,357.32	4,555,681.56
Эрүүл мэндийн даатгал	32,536,088.31	84,164,316.16
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,082,300.00	55,485,970.00
Гэрэл, цахилгаан	19,121,600.00	18,744,600.00
Түлш, халаалт	38,787,700.00	29,909,612.00
Цэвэр, бохир ус	15,173,000.00	6,831,758.00
Байрны түрээс	00.00	00.00

Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
Хангамж, бараа материалын зардал	120,193,170.99	98,162,569.60
Бичиг хэрэг	49,997,526.26	35,443,579.00
Тээвэр, шатахуун	34,965,050.00	20,825,850.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	28,775,422.00	41,193,140.60
Ном, хэвлэх	5,585,681.73	00.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	869,491.00	700,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,164,399.00	12,638,591.00
Урсгал засвар	2,164,399.00	12,638,591.00
Томилолт, зочны зардал	8,370,700.00	42,083,500.00
Дотоод албан томилолт	6,553,000.00	42,083,500.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,817,700.00	00.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,123,813,950.21	6,941,039,530.12
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,115,973,156.21	6,932,302,110.12
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,340,000.00	00.00
Даатгалын үйлчилгээ	2,263,000.00	2,240,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	989,220.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,140.00	99,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,169,120.00	5,266,100.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,969,534.00	142,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	932,799,314.42	765,004,144.69
Бараа үйлчилгээний бусад зардал	255,964,903.00	352,834,719.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,107,500.00	26,130,320.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	644,726,911.42	386,039,105.69
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	618,966,943.98	818,950,665.30
Засгийн газрын урсгал шилжүүлэг	160,178,355.14	180,795,400.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	160,178,355.14	180,795,400.00
Бусад урсгал шилжүүлэг	334,680,775.00	86,563,878.04
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	72,076,400.00	4,966,000.00
Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	142,968,056.00	47,697,878.04
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	119,636,319.00	33,900,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	551,591,387.26
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	551,591,387.26
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,107,813.84	00.00

Төвлөрүүлэх шилжүүлэг	124,107,813.84	00.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	8,682,425,789.80
Дотоод эх үүсвэрээр	00.00	8,682,425,789.80
Бусад хөрөнгө	00.00	8,682,425,789.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,422,378,393.23	159,309,094.90
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,013,992.10	13,588,919.70
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,013,992.10	13,588,919.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,013,992.10)	(13,588,919.70)
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,420,364,401.13	145,720,175.20



3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	4,118,767,312.61	7,128,435,414.03
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	4,118,767,312.61	7,128,435,414.03
Тайлант үеийн үр дүн			1,420,364,401.13	1,420,364,401.13
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,683,631,713.74	8,693,299,815.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(20,268,551.95)	(20,268,551.95)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,663,363,161.79	8,673,031,263.21
Тайлант үеийн үр дүн			145,720,175.20	145,720,175.20
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,809,083,336.99	8,818,751,438.41



3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,093,471,833.70	19,444,228,595.45
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,398,727.70	3,064,921.00
Нийтлэг татварын бус орлого	16,398,727.70	3,064,921.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	16,398,727.70	3,064,921.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,368,162.70	3,064,921.00
Бусад орлого	2,030,565.00	00.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,093,471,833.70	19,444,228,595.45
Улсын төвлөрсөн төсвөөс	7,775,852,091.00	18,459,727,468.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,775,852,091.00	18,459,727,468.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,301,221,015.00	981,436,206.45
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,801,483,296.00	492,149,206.45
ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	499,737,719.00	489,287,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,043,242,993.70	10,453,567,996.45
УРСГАЛ ЗАРДАЛ	10,043,242,993.70	10,453,567,996.45
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,407,028,653.02	9,632,817,331.15
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,606,907,915.81	1,668,845,491.28
Үндсэн цалин	1,378,690,009.81	1,018,704,184.00
Нэмэгдэл	14,273,170.00	386,644,081.27
Унаа хоолны хөнгөлөлт	123,156,336.00	131,248,199.01
Гэрээт ажлын хөлс	90,788,400.00	132,249,027.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,595,800.00	186,737,879.63
Тэтгэврийн даатгал	179,595,800.00	186,737,879.63
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,082,300.00	55,485,970.00
Гэрэл, цахилгаан	19,121,600.00	18,744,600.00
Түлш, халаалт	33,087,700.00	29,909,612.00
Цэвэр, бохир ус	15,173,000.00	6,831,758.00
Хангамж, бараа материалын зардал	63,303,500.00	96,873,165.06
Бичиг хэрэг	15,670,400.00	31,777,690.00
Тээвэр, шатахуун	15,226,900.00	20,699,900.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	27,658,900.00	43,523,575.06

Ном, хэвлэх	2,800,000.00	00.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,947,300.00	872,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	6,431,388.00	17,359,691.00
Урсгал засвар	6,431,388.00	17,359,691.00
Томилолт, зочны зардал	10,199,800.00	42,470,100.00
Дотоод албан томилолт	10,199,800.00	42,470,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,179,015,770.21	7,161,801,132.64
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,162,067,976.21	7,146,564,562.64
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,340,000.00	00.00
Даатгалын үйлчилгээ	2,263,000.00	2,240,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	989,220.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,140.00	99,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,746,620.00	11,036,550.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,499,034.00	871,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	288,492,179.00	403,243,901.54
Бараа үйлчилгээний бусад зардал	256,069,400.00	376,591,581.54
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,422,779.00	26,652,320.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	636,214,340.68	820,750,665.30
Засгийн газрын гадаад шилжүүлэг	160,178,355.14	180,795,400.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг	160,178,355.14	180,795,400.00
Бусад урсгал шилжүүлэг	337,560,009.00	88,363,878.04
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	72,076,400.00	4,966,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	142,968,056.00	47,697,878.04
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	122,515,553.00	35,700,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	138,475,976.54	551,591,387.26
Төвлөрүүлэх шилжүүлэг	138,475,976.54	551,591,387.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50,228,840.00	8,990,660,599.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50,228,840.00	8,990,660,599.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,228,840.00	8,990,660,599.00
Дотоод эх үүсвэрээр	50,228,840.00	8,990,660,599.00
Бусад хөрөнгө	00.00	8,855,450,934.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	50,228,840.00	00.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	135,209,665.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(50,228,840.00)	(8,990,660,599.00)

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,523,066,700.00	18,159,244,917.94	1,363,821,782.06	93.0%
УРСГАЛ ЗАРДАЛ	10,214,659,700.00	9,303,793,983.94	910,865,716.06	91.1%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,865,585,800.00	9,034,634,705.90	830,951,094.10	91.6%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,733,907,200.00	1,668,845,491.28	65,061,708.72	96.2%
Үндсэн цалин	1,045,926,700.00	1,018,704,184.00	27,222,516.00	97.4%
Нэмэгдэл	400,704,800.00	386,644,081.27	14,060,718.73	96.5%
Унаа хоолны хөнгөлөлт	133,098,200.00	131,248,199.01	1,850,000.99	98.6%
Гэрээт ажлын хөлс	154,177,500.00	132,249,027.00	21,928,473.00	85.8%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,730,200.00	186,737,879.63	3,992,320.37	97.9%
Тэтгэврийн даатгал	190,730,200.00	186,737,879.63	3,992,320.37	97.9%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,663,300.00	55,485,970.00	11,177,330.00	83.2%
Гэрэл цахилгаан	18,930,400.00	18,744,600.00	185,800.00	99.0%
Түлш, халаалт	33,963,400.00	29,909,612.00	4,053,788.00	88.1%
Цэвэр, бохир ус	13,769,500.00	6,831,758.00	6,937,742.00	49.6%
Хангамж, бараа материалын зардал	106,537,200.00	89,143,412.35	17,393,787.65	83.7%
Бичиг хэрэг	26,219,000.00	25,940,690.00	278,310.00	98.9%
Тээвэр, шатахуун	36,474,900.00	19,474,900.00	17,000,000.00	53.4%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,025,700.00	41,955,822.35	69,877.65	99.8%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,817,600.00	1,772,000.00	45,600.00	97.5%
Эд хогшил, худалдан авах	43,444,400.00	42,072,200.00	1,372,200.00	96.8%
Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	29,689,400.00	310,600.00	99.0%
Урсгал засвар	13,444,400.00	12,382,800.00	1,061,600.00	92.1%
Томилолт, зочны зардал	46,852,400.00	13,916,600.00	32,935,800.00	29.7%
Дотоод албан томилолт	46,852,400.00	13,916,600.00	32,935,800.00	29.7%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,531,444,200.00	6,855,212,737.64	676,231,462.36	91.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,506,911,300.00	6,839,976,167.64	666,935,132.36	91.1%
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,828,500.00	00.00	1,828,500.00	
Даатгалын үйлчилгээ	2,240,400.00	2,240,400.00	0.00	100.0%
Тээврийн хэрэгслийн татвар	990,000.00	989,220.00	780.00	99.9%

Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00	0.00	100.0%
Мэдээллийн технологийн зардал	16,900,000.00	11,036,550.00	5,863,450.00	65.3%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,475,000.00	871,400.00	1,603,600.00	35.2%
Бараа үйлчилгээний бусад зардал	146006900.00	123220415.00	22,786,485.00	84.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	103,288,400.00	96,568,095.00	6,720,305.00	93.5%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,718,500.00	26,652,320.00	16,066,180.00	62.4%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	349073900.00	269159278.04	79,914,621.96	77.1%
Засгийн газар хоорондын шилжүүлэг	180,795,400.00	180,795,400.00	0.00	100.0%
Засгийн газрын гадаад шилжүүлэг	180,795,400.00	180,795,400.00	0.00	100.0%
Бусад урсгал шилжүүлэг	168,278,500.00	88,363,878.04	79,914,621.96	52.5%
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,319,300.00	4,966,000.00	353,300.00	93.4%
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал	127,259,200.00	47,697,878.04	79,561,321.96	37.5%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,700,000.00	35,700,000.00	0.00	100.0%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,308,407,000.00	8,855,450,934.00	452,956,066.00	95.1%
Дотоод эх үүсвэрээр	9,308,407,000.00	8,855,450,934.00	452,956,066.00	95.1%
Бусад хөрөнгө	9,308,407,000.00	8,855,450,934.00	452,956,066.00	95.1%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,523,066,700.00	18,462,792,389.00	1,060,274,311.00	94.6%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,523,066,700.00	18,459,727,468.00	1,063,339,232.00	94.6%
Улсын төсвөөс санхүүжих	19,523,066,700.00	18,459,727,468.00	1,063,339,232.00	94.6%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		3,064,921.00	(3,064,921.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,064,921.00	(3,064,921.00)	
Ажиллагсдын тоо	121.00	121.00		100.0%
Удирдах ажилтан	13.00	13.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	100.00	100.00		100.0%
Үйлчлэх ажилтан	8.00	8.00		100.0%

